



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 29 өдөр

Дугаар Д/375

Хэрлэн сум

Хяналт тавьж дүгнэлт гаргах
ажлын хэсэг байгуулах

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, “Газрын хэвлийн тухай” хуулийн 7 дугаар зүйл 7.2.1, “Ашигт малтмалын тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын нөхөн сэргээлт, уул уурхайн олборлолт, газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянах, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Байгаль орчин аялал, жуулчлалын газрын дарга

Нарийн бичгийн
Дарга:

Байгаль орчин аялал, жуулчлалын газрын Геологи
уул уурхайн хяналтын улсын байцаагч

Гишүүд:

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн Байгаль орчин, уул уурхайн бодлого
хариуцсан ахлах мэргэжилтэн

Байгаль орчин аялал жуулчлалын газрын Байгаль
орчны хяналтын улсын /ахлах/ байцаагч

Байгаль орчин аялал жуулчлалын газрын Газар,
газрын хэвлий түүний баялгийн ашиглалт, уул
уурхай, БОНБҮнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Сав газрын захиргааны мэргэжилтэн

Тухайн сумын Байгаль орчны хяналтын улсын
байцаагч, байгаль хамгаалагч

Тухайн сумын газрын даамал


Нөлөөллийн бүс дэх иргэдийн төлөөлөл

2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулж байгаа иргэн аж ахуй нэгжийн тухайн жилийн менежментийн төлөвлөгөөнд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

3. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн нэгдсэн дүн мэдээг 12 дугаар сарын 30-ны дотор аймгийн Засаг даргад танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны А/493 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ